

## МОНГОЛ УЛСЫН ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2026 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Дугаар ...

Улаанбаатар хот

### Тариф батлах тухай

Эрчим хүчний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4, 9.2 дахь хэсэг, Захиргааны ерөнхий хуулийн 67 дугаар зүйлийн 67.2 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2026 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн 181 дүгээр тогтоолын 5 дугаар хэсэг, Эрчим хүчний зохицуулах хорооны 2024 оны 504 дүгээр тогтоолоор баталсан "Цахилгаан, дулааны эрчим хүчний тариф тогтоох аргачлал"-ын 4.5 дугаар зүйл, "Даланзадгадын дулааны цахилгаан станц" ТӨХК-ийн 2024 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн 01/397 дугаар албан бичгээр ирүүлсэн тарифын саналыг тус тус үндэслэн Эрчим хүчний зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Өмнөговь аймгийн Даланзадгад сумын төсөвт байгууллагад борлуулах дулааны эрчим хүчний тарифыг нэгдүгээр хавсралтаар, үйлдвэр аж ахуйн нэгж байгууллага болон орон сууц, айл өрхөд борлуулах дулааны эрчим хүчний тарифыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Баталсан тарифыг захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгэж, "Захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэл"-д нийтлэгдсэн өдрөөс эхлэн мөрдөж ажиллахыг "Даланзадгадын дулааны цахилгаан станц" ТӨХК (Г.Мөнх-Амгалан), "Даланзадгадын дулаан хангамжийн газар" ОНӨААТҮГ (Б.Мөнх-Амар)-т тус тус үүрэг болгосугай.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Үнэ, тарифын газар (Б.Эрдэнэбулган)-т даалгасугай.

4. Энэ тогтоол гарсантай холбогдуулан Эрчим хүчний зохицуулах хорооны "Тариф батлах тухай" 2022 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн 521, 2023 оны 08 дугаар сарын 23-ны өдрийн 541, 2025 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн 25, "Тогтоолд өөрчлөлт оруулах тухай" 2025 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн 185 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болгосугай.

ГАРЫН ҮСЭГ

Эрчим хүчний зохицуулах хорооны  
2026 оны ... дугаар сарын ...-ны өдрийн  
... дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт

**ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГАД  
БОРЛУУЛАХ ДУЛААНЫ ЭРЧИМ ХҮЧНИЙ ТАРИФ**

Өмнөговь аймгийн Даланзадгад сумын хэрэглэгчдэд борлуулах дулааны эрчим хүчний тариф (НӨАТ-гүй)-ыг ангиллаас нь хамааруулан төлбөр тооцох үзүүлэлтийн нэгжид дараах байдлаар тогтооно:

№	Хэрэглэгчийн ангилал		Хэмжих нэгж	Тариф /НӨАТ-гүй/
1	Төсөвт байгууллага	Эзлэхүүнээр халаалт	Төг/м <sup>3</sup>	3,200.0
		Хэмжүүрээр халаалт	Төг/ГЖ	49,882.0

-оОо-

*Эрчим хүчний зохицуулах хорооны  
2026 оны ... дугаар сарын ...-ны өдрийн  
... дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт*

**ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ҮЙЛДВЭР, АЖ АХУЙН НЭГЖ БАЙГУУЛЛАГА  
БОЛОН АЙЛ ӨРХӨД БОРЛУУЛАХ ДУЛААНЫ ЭРЧИМ ХҮЧНИЙ ТАРИФ**

Өмнөговь аймгийн Даланзадгад сумын хэрэглэгчдэд борлуулах дулааны эрчим хүчний тариф (НӨАТ-гүй)-ыг ангиллаас нь хамааруулан төлбөр тооцох үзүүлэлтийн нэгжид дараах байдлаар тогтооно:

№	Хэрэглэгчийн ангилал		Хэмжих нэгж	Тариф /НӨАТ-гүй/
1	Үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллага	Эзлэхүүнээр халаалт	Төг/м <sup>3</sup>	2,276.0
		Хэмжүүрээр халаалт	Төг/ГЖ	49,882.0
2	Орон сууцны халаалт (дотуур байр, подвал, “00” –ын өрөөний халаалт хамаарна)		Төг/м <sup>2</sup>	1,400.0
3	Ахуйн хэрэгцээний халуун ус халаасан дулаан	Халаалтын улиралд	Төг/хүн	1,870.0
		Халаалтын бус улиралд	Төг/хүн	2,806.0
4	Дулааны эрчим хүчний үйлчилгээний тариф	40 м <sup>2</sup> хүртэлх талбайтай айл өрх	Төг/сар	3,300.0
		41 м <sup>2</sup> -аас 80 м <sup>2</sup> хүртэлх талбайтай айл өрх	Төг/сар	5,500.0
		81 м <sup>2</sup> -аас дээш талбайтай айл өрх	Төг/сар	11,000.0